

ХЯТАДЫН ЭРТНИЙ НИЙСЛЭЛ ХОТУУД

Т.СОДНОМЦОГ*

Одоогийн Бээжин, Ши-ань, Лүэ-янь Кайфэнь, Наньжин, Ханьжоу бол Хятадын эртний алдартай нийслэл юм.

Бээжин хот гурван мянга гаруй жилийн түүхтэй. Бүр эрт Чунь-чу болон байлдаант улсын үед Ень улсын нийслэл байсан болохоор түүхэнд Ень-жин гэж нэрлэдэг байжээ. МЭ 1153 онд Алтан улс нийслэлээ Хүй-нин фу-гээс Бээжинд шилжүүлж дундад нийслэл гэж нэрлэжээ. Түүнээс хойш Юань, Мин, Чин улсын гурван төр Бээжин хотыг нийслэлээ болгож иржээ.

Ши-ань бол Хятадын эртний соёлын төвийн нэг юм. МЭӨ XI зууны үед баруун Жу улс энэ хотын баруун өмнө байгаа Фэншуй голын зүүн эрэг дэх Хо-жинд нийслэлээ байгуулсан байна. МЭӨ хоёр зуун хоёр онд Лиу-бан бүх улсыг нэгтгэн баруун Хань улсыг байгуулж Вэй-шуй голын хөвөөнд төвөө байгуулж Чан-ань хэмээн нэрлэсэн. Энэ нь одоогийн Чан-ань хотоос ойр байдаг. Түүнээс хойш урд Жоу улс, урд Чин улс, хойд Чин улс, баруун Вэй улс, умард Жу улс, Сүй улс, Тан улсын засаг захиргаа энд төвлөрч байсан байна.

Тан улсын үеийн нийслэл Чан-ань нь баруун Хань улсын үеийн хуучин Чан-ань биш харин түүний зүүн өмнөд хэсэгт байгуулсан өөр хот юм. Лүэ-янд зүүн Жоу улс, зүүн Хань улс, Вэй улс, баруун Жинь улс, хойд Вэй улс, Хойд Лиан улс, хойд Тан улс засаг захиргааны төвөө буюу нийслэлээ байгуулж байжээ. Сүн улс, Тан улсын нийслэл нь Чан-аньд байсан боловч зарим хаан нь үргэлж Лүэ-янд суудаг учраас түүнийг “зүүн нийслэл” гэдэг байжээ.

Кай-фэнд байлдаант улсын үеийн Вэй улс нийслэлтэй байжээ. Таван төрийн үеийн хойд Жинь улс, хойд Хань улс, хойд Жоу улс, энд төвлөрч зүүн нийслэл гэдэг байлаа. Хожим нь умард Сүн улс мөн Кай-фэнд нийслэлээ байгуулсан байна.

Нань-жин нь гурван улсын үеийн У улс, зүүн Жинь улс, Сүн улс, Чи улс, Лиан улс, Чэн улсын нийслэл байжээ. Өмнөд Тан улсын хаан болон Мин улсын эхний үеийн хаан Нань-жинд нийслэлээ байгуулсан байна.

Ханьжоу бол таван төрийн арван улсын үеийн нийслэл байсан түүхтэй, өмнөд Сүн улс бас Ханьжоуд нийслэлтэй Линь аньфу гэдэг байжээ.

*Т.Содномцог. МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн 4-р дамжааны оюутан.